



СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.13 №29 (29)

ҮЙЛ ЯВДАЛ

АВТО ЗАМЫН АНХАН ШАТНЫ



ТӨСӨВЧНӨӨР МЭРГЭШЛЭЭ

Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газар

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд “Монголын авто замчдын холбоо” ТББ-аас зохион байгуулсан Авто замын анхан шатны төсөвчний цахим сургалтад Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газар болон харьяа ангиудын зарим офицер, ажилтан албан хаагчид хамрагдлаа.

Хоёр долоо хоног үргэлжилсэн сургалтын шалгалтад тэнцсэн бүрэлдэхүүнд зэрэгтэй төсөвчний удирдлага дор төсөв бодох эрхийн гэрчилгээ олгосон юм. Төгсөгчид авто зам, төмөр замын доод бүтэц, аэродром, ус зайлуулах байгууламж, гүүр болон дээрх байгууламжийн засвар, арчлалтын хяналтын төсвийг зохиож, худалдан авах ажиллагаанд оролцох, төсвийн үнэ бүрдэл, гүйцэтгэлийг хянах бүрэн чадамжтай болж байгаа юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
Өдөр	Шөнө
+3	-6
ӨМНӨД СУДАН	
Өдөр	Шөнө
+33	+23
АФГАНИСТАН	
Өдөр	Шөнө
+20	+10

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.845.00	2.856.00
EUR	3.363.00	3.422.00
CNY	433.50	436.90
RUB	36.30	37.90
JPY	25.78	26.27
KRW	2.44	2.58

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 1
2021.04.13.

МЯГМАР ГАРАГ/
**ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ
САРЫН ДӨРВӨН НОГООН
ЦАГААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Нас ахар болно

Наран ургах, шингэх:
06.07-19.39

Барилдлага:

Арвидах

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Суудал:

Хий.

Аргын тооллын 4 дүгээр сарын 13, Анаараг гараг. Билгийн тооллын 1, Гоё хүүхэн одтой, цагаагчин туулай өдөр. Өдрийн наран 6 цаг 07 минутад мандан, 19 цаг 39 минутад жаргана. Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, сэтгэлд сэтгэй газар очих, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Дашнямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ХОЛБООЧДЫН ХЭЭРИЙН СУРГУУЛЬ АМЖИЛТАЙ ЯВАГДАЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Зэвсэгт хүчний 013 дугаар анги

Зэвсэгт хүчний 2020-2021 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө, ангийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу холбоочдын тусгай тактикийн хэргийн сургуулийг “Холбооны ангиуд бүрэн салбараар бүсийн командлалуудын холбоог хангах нь” сэдвийн хүрээнд анх удаа МБР-ын байлдааны буудлагатай тактикийн хэргийн сургуультай хамтатган Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийн районд амжилттай зохион байгууллаа.

Энэ үеэр хэргийн холбооны зангилгааг дэлгэх, аналог болон тоон радио релейний шугамыг үүсгэн, видео теле хурал явуулах хувилбаруудыг боловсруулах,

дотоод сүлжээг ашиглан мэдээ, мэдээлэл дамжуулах, харилцан ажиллагааны радио торуудын бэлэн байдлыг шалган, экипаж, тоотуудын гар нийлэмжтэй ажиллагаа, офицеруудын оператив, тактикийн мэдлэгийг дээшлүүлсэн нь ач холбогдол өндөртэй болов. Мөн РЭТ-ийн туршилт судалгааны төвийн бүрэлдэхүүн нисгэгчгүй нисэх хэрэгсэл буюу дрон ашиглан мэдээ мэдээлэл дамжуулах, эсрэг талын нисгэгчгүй нисэх хэрэгслийн давтамжийг тодорхойлж, радио даралт явуулснаар удирдлагыг алдагдуулж, газардуулах, мэдээ мэдээллийг олборлох зэрэг туршилт, судалгааны ажлыг амжилттай хэрэгжүүлээ.

МБР-ын байлдааны буудлагатай тактикийн хэргийн сургуульд Зэвсэгт хүчний 013 дугаар ангиас байнгын

болон ХЦАХ-дын салаа тус бүр нэг, Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн эмэгтэй цэргийн алба хаагчийн нэг тасагтай байнгын бүрэлдэхүүний нэг салаа хуягт тээвэрлэгчээр хүч нэмэгдүүлэн оролцсон юм.

Сургуулиар хорлон сүйтгэх бүлгийн ажиллагааг таслан зогсоох, хөнөөлийн голомтоос хүн, техникийг татан гаргах, бүслэн хаах, самналтын бүлгүүдийн ажиллагаа, РЭТ-ийг зохион байгуулах, холбооны зангилгааны аюулгүй байдлыг хангах зэрэг тактикийн ажиллагааг амжилттай зохион байгуулж, офицеруудын гал удирдах чадвар, бие бүрэлдэхүүний бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг хангав.

Хошууч С.БАТБААТАР

“ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ТӨЛӨВШИЛ” ЦАХИМ СУРГАЛТ БОЛОВ

ҮБХИС

Энэ сарын 5-9-ний өдрүүдэд хувь хүний хөгжлийн цахим сургалт явагдлаа.

Тус сургалтаар АТСА-ны дарга, доктор (Ph.D), дэд профессор, дэд хурандаа Д.Отгонцэцэг “Хүн байхын учир”, ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D), дэд профессор С.Болорцэцэг “Монголын уламжлалт зан заншил, харилцаа”, ахлах мэргэжилтэн Л.Батжаргал “Хүний хөгжил, өөрийгөө бүтээх зам”, Аюулгүй байдлын дээд сургуулийн ЭЗМТ-ийн дарга Д.Сарангэрэл “Хувь хүний харилцааны ур чадвар”, тус тэнхимийн багш Д.Гандолгор “Хувь хүний манлайлал” сэдвээр цуврал лекц уншив.

Сургалтад ҮБХИС-ийн офицер, ахлагчийн бүрэлдэхүүн, сонсогч, хугацаат цэргийн алба хаагчид хамрагдлаа.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

15014+704

ЭДГЭРСЭН

9159+357

НАС БАРСАН

25+3

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

1623+20

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

271

ЭДГЭРСЭН

1359

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 134,957,021

Эдгэрсэн

Нийт: 109,840,495

Нас барсан

Нийт: 2,918,752

КОВИД-19 ЦАР ТАХАЛ

МАСЛАР	МАСЛАР
АНУ-30,965,977	АНУ-30,965,977
БРАЗИЛ-13,373,174	БРАЗИЛ-13,373,174
ЭНЭТХЭГ-13,358,805	ЭНЭТХЭГ-13,358,805
ФРАНЦ-4,945,238	ФРАНЦ-4,945,238
ОХУ-4,632,688	ОХУ-4,632,688

КОВИД-19 ЦАР ТАХАЛ

НАС БАРЛАТ	НАС БАРЛАТ
АНУ-558,843	АНУ-558,843
БРАЗИЛ-348,718	БРАЗИЛ-348,718
МEXИК-207,020	МEXИК-207,020
ЭНЭТХЭГ-169,275	ЭНЭТХЭГ-169,275
ИХ БРИТАНИ-127,080	ИХ БРИТАНИ-127,080

ЦАХИМ ШУУДАНД

Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн тусгай ротын бие бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 6/45 дугаар албан бичигт туссан Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах бэлэн байдлыг хангах, унтраах үйл ажиллагаанд оролцох үеийн аюулгүй байдлын талаарх сэрэмжлүүлгийг нийт бие бүрэлдэхүүнд танилцууллаа.

Орон нутгийн цагдаагийн газартай хамтран явуулсан танилцуулга сургалтын хүрээнд ротын үндсэн байрлал дахь барилга байгууламж, тавиулан, агуулах, радиолокацийн станцуудын ойр орчмын хуурай өвсийг цэвэрлэн учирч болзошгүй ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллалаа.



ОЮУТНЫ ДЭЛХИЙН АВАРГЫН МӨНГӨН МЕДАЛЬТАЙ БАЙЛДАГЧ

Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангид урлаг, спортоор улс, тив, дэлхийд амжилт гаргасан шилдэг залуус хугацаат цэргийн алба хааж байна.

Авьяаслаг, спортлог дайчдын нэг нь Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Ц.Бат-Эрдэнэ юм. Тэрээр тээвэр-дээд цэргийн спортоор зургаан жил хичээллэхдээ

гаргасан амжилт нь тун их. Тухайлбал, 2014 онд БНСУ-ын Ерөнхийлөгчийн нэрэмжит Олон улсын таэквондогийн тэмцээнээс мөнгө, 2015 онд "Халхын голын байлдааны ялалт-75" болон "Ирээдүйн одод", Ерөнхийлөгчийн нэрэмжит таэквондогийн аварга шалгаруулах тэмцээнүүдээс хүрэл, 2016 онд Хүүхдийн V их наадмаас мөнгө, 2016 онд "Токио-2020" олон улсын тэмцээн болон "Касс тоун"-оос хүрэл медаль хүртжээ.

Түүнчлэн 2017 онд зохиогдсон Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл, 2018 онд Дундговь аймгийн аварга шалгаруулах тэмцээнээс алт, БНСУ-д явагдсан таэквондогийн оюутны аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль хүртсэн гээд амжилтыг нь тоочвол их. Таэквондогийн спортын нэгдүгээр зэрэг, хар бүстэй тамирчин маань Дундговь

аймгийн МСҮТ-ийг авто засварчин мэргэжлээр суралцаж төгссөн. Өдгөө онжавуудынхаа хамтаар Зэвсэгт хүчний 2021 оны аварга шалгаруулах марш тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор бэлтгэлдээ гарсан байна. Цэргийн албаны талаар хуучлахдаа "Таэквондогийн спорт бусдыг хүндэтгэх, тэсвэр тэвчээртэй, үнэнч шударга, эр зоригтой байхыг шаарддаг. Энэ чанараараа цэргийн албатай маш их төстэй. Манай онжавууд өнгөрсөн 2 дугаар сараас эхлэн бэлтгэлдээ орсон. Хүчтэй өрсөлдөгч байж, медалийн тавцанд гарахын төлөө хичээж байна" гэв.

Тамирчин дайчин маань хүсэл мөрөөдлөөр дүүрэн нэгэн бөгөөд түүнийг биелүүлэхээр хүч, хөдөлмөрөө бүрэн зориулж байгааг харахад урамтай сайхан байлаа.

"ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАХИМ ГҮЙЛТ-2021"-ИЙН ДЭД БАЙРТ ШАЛГАРЛАА

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Улс орон даяар 14 хоногийн хугацаатай үргэлжилсэн "Эрүүл мэндийн цахим гүйлт-2021" өдөрлөгт Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн баг буюу ахлах дэслэгч Л.Баттулга даргатай тамирчид дэд байрт шалгарсан амжилт үзүүлээ.

Цахим гүйлтийг нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан бөгөөд Баян-Өлгий аймагт явагдсан тэмцээнд барилгачин дайчид бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн багийг ардаа хол хаясан байна. Энэхүү өдөрлөгийн



зорилго нь "Ковид-19" цар тахлын үед иргэдийг энгийн дасгал хөдөлгөөн, алхалт, гүйлтээр хичээллэхэд уриалах, спортоор хичээллэгчдийн

тоог нэмэгдүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдраа чийрэгжүүлж дархлаажуулах байлаа. Дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН


ХҮН БҮРТ ОЛДОХГҮЙ ХИЙМОРЬЛОГ САЛБАР



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

БНМАУ-ын баатар, ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангиас хугацаат цэргийн алба хаагчид руу чиглэсэн соёл хүмүүжлийн арга хэмжээг шат дараатай зохион байгуулж байна.

Тухайлбал, "Гурван цагийн хэлхээ" сэдэвт цахим ярилцлагыг өнгөрсөн амралтын өдрөөр явуулж бэлтгэл хурандаа С.Энхтайван "Эр хүн байхын утга учир", "Цэргийн алба хаагчийн ёс суртахуун", "Цэргийн алба хаагчийн төлөвшил" сэдвээр хугацаат цэргийн алба хаагчидтай чөлөөт ярилцлага хийж, өөрийн алба хааж байсан үеийнхээ дурсамжийг дэлгэсэн юм. Тэрээр дурсамждаа өөрийг нь сонсогч байх үеэс өнөөгийн үе маш их өөрчлөгдсөн төдийгүй хууль эрх зүй, хангалт үйлчилгээ



гээд бүх талаар шинэчлэгдэж, алба хаах орчин нөхцөл эрс сайжирсан хэмээн онцлоод эх оронч хүмүүсийн хамгийн түрүүнд хийх алхам бол цэргийн жинхэнэ албаа хаах явдал юм гэв.

Үргэлжлүүлэн "Би та нараар бахархаж байна. Үеийн олон залуустаа үлгэр дуурайл үзүүлж, Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхээр цэргийн албанд татагдан ирсэн нь та бүхнийг ямар хариуцлагатай, ухамсар сайтай вэ гэдгийг нотлон харуулж байна. Халагдсаныхаа дараа цэргийн алба ямар хийморьлог, нөхөрлөлөөр цэнэглэгдсэн орчин байсан бэ гэдгийг та бүхэн илүү их ойлгоно. Өөрийнхөө амьдрал замнал, ажил үйлсдээ цэргийн албанаас сурсан эрдэм мэдлэг, төлөвшил, итгэл үнэмшлээ зарчим болговол алзахгүй" гэж захилаа.

Ахмад Д.ГАНБААТАР

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИДАЙ ЦАХИМ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Увс аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Увс аймгаас 2020 оны нэг, хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдаж Зэвсэгт хүчний 340 дүгээр анги, Хилийн 0285 дугаар анги, Завхан аймаг дахь Хилийн 0277 дугаар ангид алба хааж байгаа цэргүүдийг ар гэрийнхэнтэй

нь цахимаар уулзуулах ажлыг зохион байгууллаа.

Тус арга хэмжээг дээрх ангиудтай хамтран энэ сарын 9-нд захидал илгээх, утсаар яриулах хэлбэрээр зохион байгуулсан нь иргэдийн талархалыг хүлээсэн арга хэмжээ боллоо.

Хошууч Ө.СОЁМБО

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН АР ГЭРТ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭВ



Булган аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нэр хүндийг иргэдийн дунд өргөх зорилгоор тус аймгийн Цэргийн штаб дараах ажлыг зохион байгууллаа.

Тус Цэргийн штабын дарга, хурандаа Х.Золзаяа Булган, Бугат суманд ажиллаж, Зэвсэгт хүчний 110, 326, 014 болон Хилийн цэргийн 0243, 0101 дүгээр ангид цэргийн алба хааж байгаа зарим цэргийн алба хаагчийг эцэг

эх, ар гэрийнхний төлөөлөлтэй уулзаж, нэгтгэл ангийнх нь удирдлагуудтай холбогдон утсаар яриууллаа.

Мөн Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар товч мэдээлэл өгч, цэргийн албаны талаарх эцэг эхчүүдийн санал бодлыг сонссон бөгөөд цэргийн алба хааж байгаа залуусын ахуй амьдралын судалгааг гаргаж эцэг эх нь өрх толгойлсон, ажилгүй байгаа нэр бүхий 6 алба хаагчийн ар гэрт тус бүр 50 мянган төгрөгийн тусламж үзүүллээ.

ЦАХИМААР УУЛЗУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Тус аймгаас 2020 оны II ээлжээр цэргийн жинхэнэ албанд татагдан Зэвсэгт хүчний 123, 340 дүгээр ангид алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдыг аймаг, сум орон нутгийн удирдлага ар гэрийнхэнтэй нь цахимаар уулзуулах арга хэмжээг зохион байгууллаа.

Уулзалтын арга хэмжээнд аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал, Цэргийн штабын дарга, хурандаа Г.Үнэнбаяр, сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар болон эцэг эхчүүд оролцов. Уулзалтын эхэнд аймгийн Засаг дарга хугацаат алба хааж буй цэрэг дайчдад хандан мэндчилгээ дэвшүүлсэн бөгөөд тэрээр Батлан хамгаалахын сайдтай хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны дагуу жил бүр цэрэг дайчдаа эргэж, тэдний

албаны нөхцөл байдалтай танилцах арга хэмжээг зохион байгуулдаг уламжлал цар тахлын нөхцөл байдлаас хамаарч энэ удаад хойшлогдож байгааг дуулгаад хуулиар хүлээсэн цэргийн алба хаах үндсэн үүргээ нэр төртэй биелүүлж, өргөсөн тангарагтаа үнэнч байж, цэргийн хэргийн мэдлэг чадвараа сайн эзэмшээд ирэхийг хүслээ. Энэ үеэр цэрэг бүр ар гэрийн төлөөлөлтэйгээ "уулзаж", санал сэтгэгдлээ хуваалцсан юм. Мөн уулзалтад оролцсон ангиуд өөрсдийн үйл ажиллагаа, чиг үүргийн талаар товч танилцуулж, урлаг соёлын мэндчилгээ дэвшүүлэв.

Тус арга хэмжээнд эцэг эхчүүд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, цаашид хугацааны давтамжтай явуулж байх хүсэлтээ илэрхийллээ.

Хошууч Г.БАВУУДОРЖ